



## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Санхүүжилтийн эх үүсвэр: Урсгал төсөв

Зориулалт: Хэнтий аймгийн Татварын газрын байранд харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх

Хэрэгжүүлэх хугацаа: 2024-2026 он

| № | Техникийн тодорхойлолт  | Тавигдах шаардлага  |
|---|---|---|
| 1 | Хэнтий аймгийн Татварын газрын 1100 мкв талбай бүхий албан конторын барилга, автогражийн байр, 2758 мкв гадна талбай, хашаанд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх | <p>Харуул хамгаалалтын үйлчилгээ харуул хамгаалалтын үйлчилгээний хамрах хүрээ, чиг үүрэг:</p> <ol style="list-style-type: none"><li>Харуул хамгаалалтын компани нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар багт байрлах Татварын газрын зоорины буюу авто граж бүхий 4 давхар 1100 мкв талбай бүхий объект, нийтийн эдэлбэрээс бусад манай байгууллагын гадна талбай, хашаа, өмч, хөрөнгөд 24 цагийн харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.</li><li>Харуул хамгаалалтын компанийн харуул хамгаалалтын ажилтан нь "Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай" 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан жагсаалт дахь 5414 кодтой "Хамгаалалтын албаны ажилтан"-ы тодорхойлолт, гүйцэтгэх чиг үүрэгт дурдсан болон доорх үйлчилгээг үзүүлж ажиллана. Үүнд:<ol style="list-style-type: none"><li>Хамгаалах объектын өмч хөрөнгийг хулгайлах, хорлон сүйтгэх явдлаас хамгаалж, байгууллагад орох гарах хэсгийг хяналтдаа байлгаж, байгууллагын гадна, дотно аюулгүй байдлын талаарх нийтэд хамаарах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах,</li><li>Хамгаалах объектод зөвшөөрөлгүй нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор, цонх хаалгыг шалгаж, эргэж, тойрч байх,</li><li>Хамгаалах объектод нэвтрэх дотоод ажилтны болон гаднын хүний бичиг баримтыг шалгах, гарч, орж ирж байгаа хүмүүст хяналт тавих,</li><li>Дэг журмыг сахиулах, гадна дотнын аливаа эрсдэлт үйлдлээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахын тулд гаднын зочид, иргэдэд шаардлага тавих,</li><li>Хамгаалах объектод үүсэх гал түймрийн болон ус, дулаан алдах гэх мэт аюул гарвал цаг алдалгүй Цагдаа, Онцгой байдал болон холбогдох бусад байгууллагуудад мэдэгдэх,</li></ol></li><li>Монгол улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийг мөрдөж ажиллана.</li></ol> |